

БДБ-8 Ажилтны шилжилт хөдөлгөөн

Захиргааны мэдээлэл, Маягт БДБ- 8

Удирдах ажилтан, нийгмийн ажилтан, үндсэн багшийн шилжилт хөдөлгөөний маягтанд захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, үндсэн багш нарын шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг гаргана.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

Маягтны өмнөх тайлангийн үеийн ажиллагчид гэсэн 01 дүгээр мөрөнд өнгөрсөн хичээлийн жилийн БДБ-8 маягтын тайлан гаргах үед ажиллаж байгаа гэсэн 20-р мөрөнд байгаа дүнтэй ижил байна.

БДБ8 тайлан:

Өмнөх тайлангийн үед ажиллагчдын дүнг гаргахдаа энэ хичээлийн жилд ажиллаж байгаа ажилчдаас хасах болон нэмэх үйлдэл хийж гардаг бөгөөд **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багш, удирдах ажилтны шилжилт хөдөлгөөн** хэсэгт бүртгэл хөтлөснөөр гарна.

Жишээ нь:

Танай сургууль өмнөх хичээлийн жилд 18 үндсэн багштай байсан. Харин энэ хичээлийн жилд 20 багштай болсон гэж үзье.

Тэгвэл БДБ 8 тайлангийн "**Өмнөх тайлангийн үед ажиллагчид**" гэдэг дүнг гаргахдаа **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багш, удирдах ажилтны шилжилт**

хөдөлгөөнд үндсэн багш гэсэн хэсэгт Тайлант хугацаанд **нэмэгдсэн** шалтгаанд тохирох утга ард 2 гэдэг тоо оруулна.

Түүний дараа тайлангаа шинэчлэн бодуулах үйлдэл хийж тайлангаа татаж үзнэ.